# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

# 2023 2 сар

www.ubstat.mn
www.facebook.com/Багануур дүүргийн Статистикийн хэлтэс
www.1212.mn

АГУУЛГА


| | Хуудасны дугаар |
|---|---|
| ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2019-2023 ОН | 3 |
| АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД | 4 |
| НИЙГМИЙН ДААТГАЛ | 5 |
| НИЙГМИЙН ХАЛАМЖ | 6 |
| ЭРҮҮЛ МЭНД | 7 |
| ГЭМТ ХЭРЭГ | 9 |
| ҮНЭ ХАНШ | 13 |
| АЖ ҮЙЛДВЭР | 16 |
| НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 17 |

# ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, 2022 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

| Үзүүлэлт | Дүүргийн дүн | Үүнээс: хороогоор | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | I | II | III | IV | V |
| **Нийт мал** | **170805** | **37109** | **6214** | **34590** | **55283** | **37609** |
| Үүнээс: | | | | | | |
| Тэмээ | 54 | 32 | - | 20 | 2 | - |
| Адуу | 15545 | 4115 | 634 | 3424 | 3804 | 3568 |
| Үхэр | 16278 | 4162 | 1182 | 3450 | 3843 | 3641 |
| Хонь | 84995 | 17874 | 2270 | 17162 | 29866 | 17823 |
| Ямаа | 53933 | 10926 | 2128 | 10534 | 17768 | 12577 |

ХҮСНЭГТ 2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2019 II | 2020 II | 2021 II | 2022 II | 2023 II |
|---|---|---|---|---|---|---|
| **Суурин хүн ам** | **тоо** | **29 663** | **29 342** | **29433** | **29341**[1] | |
| Төрөлт | тоо | 100 | 102 | 69 | 83 | 100 |
| Нас баралт | тоо | 30 | 26 | 13 | 35 | 12 |
| Шилжиж ирсэн | тоо | 47 | 611[2] | 72 | 130 | 151 |
| Цэвэр өсөлт | хувь | 0.24 | 2.26 | 0.19 | 1.16 | 0.29' |

*'суурин хүн амын урьдчилсан тооноос тооцов.*

*1 – 2022 оны хүн амын урьдчилсан тоо*

*2 - Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл түр хязгаарласан Нийслэлийн Засаг даргын захирамжийн хугацаа дууссантай холбоотой шилжилт хөдөлгөөний бүртгэл нэмэгдсэн.*

ЗУРАГ 1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, 2022 ОН



# БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2023 оны 2 сарын эцэст 100 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна.

Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд өнгөрсөн оноос 148 (2.5 дахин бага) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН, II сарын байдлаар




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 46 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 33 (71.7%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, ШАЛТГААНААР, II сарын байдлаар




Мөн энэ хугацаанд 24 иргэн ажилд зуучлуулан орсон хувьцаат компанид 1 иргэн, хязгаарлагдмал хариуцлагатай компанид 5, улсын болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт 3, бусад байгууллагад 15 иргэн тус тус ажилд оржээ.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 13 (13.0%) нь 15-24 насны, 50 (50.0%) нь 25-34 насны залуучууд, 20 (20.0%) нь 35-44 насныхан, 17 (17.0%) нь 45-60 насныхан эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролоор, II сарын байдлаар

| Үзүүлэлт | Ажилгүйчүүдийн тоо | | Үүнээс: эмэгтэй | |
|---|---|---|---|---|
| | 2022 II | 2023 II | 2022 II | 2023 II |
| **Ажилгүйчүүд, бүгд** | **284** | **100** | **163** | **56** |
| Үүнээс: | | | | |
| Дээд боловсролтой | 69 | 46 | 52 | 31 |
| Тусгай дунд боловсролтой | 23 | 5 | 16 | 2 |
| Мэргэжлийн анхан шатны боловсролтой | 26 | 12 | 12 | 5 |
| Ерөнхий боловсролтой | 155 | 36 | 81 | 18 |
| Бага болон боловсролгүй | 11 | 1 | 2 | - |

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 46 (46.0%) нь дээд боловсролтой, 5 (5.0%) нь тусгай дунд боловсролтой, 12 (12.0%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 36 (36.0%) нь ерөнхий боловсролтой, 1 (1.0%) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ. Ажил хайгч иргэдийн 56 (56.0%) нь эмэгтэйчүүд байна.



## НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 7.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.8 (65.1%) тэрбум төгрөгөөр, зарлага 6.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.6 (10.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 3.2 (66.5%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 336.2 (7.0%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 420.9 (8.8%) сая төгрөг ҮОМШӨ сангаас, 778.5 (17.5%) сая төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 67.7 (1.4%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.

ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сараар



ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, эхний II сард

| Үзүүлэлт | 2022 | 2023 | Өсөлт бууралт | |
|---|---|---|---|---|
| | I-II | I-II | тоо | хувь |
| | сая төгрөг | | | |
| **Сангийн орлого, бүгд** | **2 897.5** | **4 784.5** | **142.0** | **165.1** |
| тэтгэврийн сан | 1 933.6 | 3 181.2 | 140.6 | 164.5 |
| тэтгэмжийн сан | 203.2 | 336.2 | 141.5 | 165.5 |
| ажилгүйдлийн сан | 40.3 | 67.7 | 142.8 | 168.0 |
| ҮОМШӨ[1]-ний сан | 224.3 | 420.9 | 173.7 | 187.7 |
| ЭМД[2]-ын сан | 496.1 | 778.5 | 131.1 | 156.9 |
| **Сангийн зарлага, бүгд** | **5 552.1** | **6 114.7** | **94.7** | **110.1** |
| тэтгэврийн сан | 4 966.0 | 5 488.8 | 93.5 | 110.5 |
| тэтгэмжийн сан | 181.5 | 212.7 | 95.3 | 117.2 |
| ҮОМШӨ-ний сан | 268.8 | 304.0 | 108.5 | 113.1 |
| Ажилгүйдлийн сан | 135.8 | 109.2 | 123.6 | 80.4 |

ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ




Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4861 хүнд 5.5 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 586 хүнд 212.7 сая төгрөгийн тэтгэмж, 220 хүнд 304.0 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 54 хүнд 109.2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.

## НИЙГМИЙН ХАЛАМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах талаар тусгасан. Үүний хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг бүхэлд нь цахимжуулж дүүрэгт санхүүжилт хуваарилалт хийгдэхгүй Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нэг данснаас зарцуулалт хийгдэж байна.



[1] Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
[2] Эрүүл мэндийн даатгал

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ, эхний II сард

| Үзүүлэлт | 2022 | | 2023 | | 2023.II / 2022.II | 2023.I-II / 2022.I-II |
|---|---|---|---|---|---|---|
| | II | I-II | II | I-II | | |
| | сая төгрөг | | | | хувь | |
| **Сангийн зарлага** | **3 185.4** | **3 213.6** | **2 581.4** | **3 782.1** | **82.5** | **117.7** |
| Тэтгэвэр | 251.4 | 251.4 | 126.9 | 254.1 | 50.5 | 101.1 |
| Тэтгэмж | 67.5 | 67.5 | 35.0 | 69.0 | 51.9 | 102.2 |
| Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж | 49.1 | 49.1 | 31.2 | 59.2 | 63.5 | 120.6 |
| "Алдарт эх" 1 одонтой эхчүүд | 117.0 | 117.0 | 111.8 | 111.8 | 95.6 | 95.6 |
| "Алдарт эх" 2 одонтой эхчүүд | 157.7 | 157.7 | 163.0 | 163.0 | 103.4 | 103.4 |
| Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж | 13.9 | 13.9 | 8.2 | 17.0 | 59.0 | 122.3 |
| Хүүхдийн мөнгөн тэтгэмж | 2 305.8 | 2 305.8 | 1 881.3 | 2 809.8 | 81.6 | 121.9 |
| 0-3 хүртэлх настны хүүхэд асаргааны тэтгэмж | 115.5 | 115.5 | 53.8 | 107.4 | 46.6 | 93.0 |
| Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт | 13.7 | 23.9 | 17.7 | 20.1 | 129.2 | 84.1 |
| ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт | 2.3 | 3.9 | 1.8 | 3.2 | 78.3 | 82.1 |
| “Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөр | 32.4 | 48.8 | 13.8 | 27.0 | 42.6 | 55.3 |
| Өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж | 0.3 | 0.3 | 0.2 | 0.6 | 66.7 | 200.0 |
| Ихэр хүүхдийн тэтгэмж | - | - | 4.0 | 6.0 | - | - |
| Онцгой тохиолдлын тэтгэмж | 2.4 | 2.4 | 2.4 | 3.6 | 100.0 | 150.0 |
| Насны хишиг | 56.4 | 56.4 | 130.3 | 130.3 | - | 231.0 |

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 443 хүнд 254.1 сая төгрөгийн тэтгэвэр, 372 хүнд 69.0 сая төгрөгийн тэтгэмж, 119 хүнд 59.2 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 252 жирэмсэн эхэд 17.0 сая төгрөгийн тэтгэмж, 9578 хүүхдэд 2.8 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, 1143 хүнд 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 107.4 сая төгрөг 1576 ахмад настанд 20.1 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлж, 1125 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 27.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэдэд 3.2 сая төгрөгийн хөнгөлөлт, ихэр хүүхдийн тэтгэмж 3 өрхөд 6.0 сая төгрөг, 3 хүнд 3.6 сая төгрөгийн онцгой тохиолдлын тэтгэмж, 2 өрх толгойлсон эх, эцэгт 0.6 сая төгрөг тус тус олгосон байна.

## ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2023 оны эхний 2 сарын байдлаар 66 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 34 (2.1 дахин) өссөн байна. Энэ хугацаанд 19.4 мянган хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 16.2 (45.4%) мянган хүнээр буурсан бол, хэвтэн эмчлүүлсэн 955 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 116 (13.8%) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 7. АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГ, эхний II сард




ХҮСНЭГТ 6. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний II сард

| Үзүүлэлт | 2022 I-II | 2023 I-II | 2023.I-II / 2022.I-II |
|---|---|---|---|
| Амаржсан эхийн тоо | 69 | 111 | 160.9 |
| Үүнээс бусад аймгийн харьяат | 12 | 45 | 375.0 |
| Амьд төрсөн хүүхэд | 69 | 113 | 163.8 |
| Үүнээс бусад аймгийн харьяат | 12 | 44 | 366.7 |
| Эхийн эндэгдэл | - | - | - |
| Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд | 1 | - | 0.0 |

ЗУРАГ 8. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар




2023 оны 2 сарын байдлаар бэлгийн замын халдварт өвчний 21 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 32.3%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 9 (30.0%) тохиолдлоор өссөн бол цочмог халдварт өвчний 44 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 67.7%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1454 (97.1%) тохиолдлоор буурсан байна.
Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 22.3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 506.3 продицмиллээр буурсан байна.

ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний II сард

| Үзүүлэлт | 2022 I-II | 2023 I-II | Өсөлт бууралт |
|---|---|---|---|
| **Бэлгийн замын халдварт өвчин** | **30** | **21** | **-9** |
| Заг хүйтэн | 15 | 10 | -5 |
| Тэмбүү | 8 | 9 | 1 |
| Трихомониаз | 7 | 2 | -5 |
| **Цочмог халдварт өвчин** | **1 498** | **44** | **-1454** |
| Цусан суулга | - | 3 | 3 |
| Салхин цэцэг | - | 37 | 37 |
| Ковид-19 | 1 496 | | -1496 |
| Рож | 1 | 1 | - |
| Сүрьеэ | 1 | 3 | 2 |
| **Нийт халдварт өвчин** | **1 528** | **65** | **-1463** |

## ГЭМТ ХЭРЭГ

2023 оны эхний 2 сарын байдлаар дүүргийн хэмжээнд 49 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6 (14.0%) хэргээр өссөн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 31.8 хувьтай байгаа нь өмнөх оноос 3.7 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, жилийн эцэст

| Хэргийн төрөл | 2022 I-II | 2023 I-II | Хэргийн өсөлт | | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | | тоо | хувь | |
| **Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд** | **43** | **49** | **6** | **14.0** | **100.0** |
| Хүний амь нас хохирсон | 1 | - | -1 | -100.0 | - |
| Хүнийг алах | - | 1 | 1 | - | 2.0 |
| Хүний эрүүл мэндэд хохирол учруулах | 18 | 16 | -2 | -11.1 | 32.7 |
| Бусдын эд хөрөнгө хулгайлах | 7 | 6 | -1 | -14.3 | 12.2 |
| Мал хулгайлах | - | 1 | 1 | - | 2.0 |
| Залилан мэхлэх | 5 | 16 | 11 | 3.2* | 32.7 |
| Дээрэмдэх | 1 | 1 | 0 | 0.0 | 2.0 |
| Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших | 3 | 1 | -2 | -66.7 | 2.0 |
| Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх | 2 | 1 | -1 | -50.0 | 2.0 |
| Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших | - | 1 | 1 | - | 2.0 |
| Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих | 4 | - | -4 | -100.0 | 0.0 |
| Хууль сахиулагчийг эсэргүүцэх | 2 | 1 | -1 | -50.0 | 2.0 |
| Эрүү шүүлт тулгах | - | 1 | 1 | - | 2.0 |
| Хуурамч бичиг баримт үйлдэх, ашиглах | - | 2 | 2 | - | 4.1 |
| Хууль бусаар ан агнах | - | 1 | 1 | - | 2.0 |
| Хэрэг илрүүлэлтийн хувь | 35.5 | 31.8 | | | |

*-дахин их

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар




Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 16 (32.7%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 16 (32.7%) нь залилан мэхлэх хэргүүд байна. Тайлант хугацаанд бусдын амь нас хохирсон хэрэг 1 (2.0%) бүртгэгдсэн бөгөөд бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэг 6 (12.2%), хуурамч бичиг баримт үйлдэх, ашиглах хэрэг 2 (4.1), мал хулгайлах, дээрэмдэх, хөрөнгө завших, бусдын эд хөрөнгийг устгах, битүүмжилсэн хураан авсан хөрөнгийг завших, хууль сахиулагчийг эсэргүүцэх, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих, хууль бусаар ан агнах хэргүүд тус бүр 1 (14.3%) бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 10. СОГТУУГААР БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар




ХҮСНЭГТ 9. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАЗАР, 2023 оны эхний 2 сард

| Хэргийн төрөл | 2022 I-II | 2023 I-II | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|
| **Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд** | **43** | **49** | **100.0** |
| Гэр, орон сууцанд | 23 | 16 | 32.7 |
| Гудамж талбайд | 4 | 5 | 10.2 |
| Олон нийтийн газарт | 2 | 5 | 10.2 |
| Аж ахуйн нэгж, байгууллагад | 2 | 9 | 18.4 |

| | | | |
|---|---|---|---|
| Автозамд | 3 | - | - |
| Бусад | 9 | 14 | 28.6 |

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг төрлөөр нь авч үзэхэд 16 (32.7%) нь гэр, орон сууцанд, 5 (10.2%) гудамж талбайд, 5 (10.2%) нь олон нийтийн газарт, 9 (18.4%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, үлдсэн хэсэг нь буюу 14 нь (28.6%) бусад газарт тус тус үйлдэгдсэн байна.

ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 2 сард




ЗУРАГ 12. ГУДАМЖ ТАЛБАЙД БОЛОН СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эхний 2 сард



ХҮСНЭГТ 10. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮМҮҮС, 2 сарын эцэст

| Үзүүлэлт | Хүний тоо | | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|
| | 2022 I-II | 2023 I-II | тоо | Хувь |
| **Гэмт хэрэгт холбогдсон хүн** | **23** | **21** | **-2** | **-8.7** |
| Үүнээс: эмэгтэйчүүд | 3 | 3 | - | - |
| хүүхэд | - | - | - | - |
| Гэмт хэргийн улмаас хохирсон хүн | 43 | 46 | 3 | 7.0 |
| Үүнээс: нас барсан | 3 | 1 | -2 | -66.7 |
| гэмтсэн | 20 | 16 | -4 | -20.0 |
| Эрүүлжигдсэн хүний тоо | 126 | 47 | -79 | -62.7 |
| Баривчлагдсан хүний тоо | 24 | 16 | -8 | -33.3 |
| Учирсан хохирол /сая төгрөг/ | 65.4 | 93.6 | 28.2 | 43.1 |
| Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/ | 23.7 | 17.4 | -6.3 | -26.6 |

ЗУРАГ 13. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ИРГЭД, хувиар, эхний 2 сарын байдлаар




2023 оны эхний 2 сард 21 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 3 (14.3%) нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд 46 иргэн гэмт хэргийн улмаас хохирсон ба 1 иргэний амь нас хохирч, 16 иргэн гэмтсэн байна. Мөн 47 иргэн согтуугаар зөрчил гарган саатуулагдаж, 16 иргэн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн иргэд 79 (62.7%) -өөр, баривчлагдсан иргэд 8 (33.3%) иргэнээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 93.6 сая төгрөгийн хохирол учирсны 17.4 (18.6%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.

# ҮНЭ ХАНШ

2023 оны 2 сарын хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

ХҮСНЭГТ 11. ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНИЙН АЖИГЛАЛТ, II сарын дундаж үнэ

| Хүнсний бараа | | Хэмжих нэгж | Хишиг-Уул супер маркет | Марал хүнсний дэлгүүр | Хэрлэн хүнсний зах | Миний нутаг супер маркет |
|---|---|---|---|---|---|---|
| "Алтан тариа" гурил | Дээд | кг | 2 850 | 2 700 | | 2 800 |
| | I зэрэг | кг | 2 300 | 2 150 | | 2 250 |
| | II зэрэг | кг | 1 750 | 1 700 | | 1 800 |
| Будаа | цагаан | кг | 4 000 | 3 800 | | 4 000 |
| | шар | кг | 3 240 | 3 200 | | 3 200 |
| Хонины мах | ястай | кг | | | 8 250 | |
| | цул | кг | | | 11 500 | |
| Үхрийн мах | ястай | кг | | | 11 500 | |
| | цул | кг | | | 13 625 | |
| Адууны мах, ястай | | кг | | | 9 000 | |
| Ямааны мах | | кг | | | 7 500 | |
| Элсэн чихэр | | кг | 3 200 | 3 000 | | 3 300 |
| Сүү /задгай/ | | л | 3 500 | | | |
| Тараг /задгай/ | | л | 4 000 | | | |
| Цөцгийн тос, Орос | | кг | 6 025 | 5 600 | | 6 050 |
| Байцаа | | кг | | | 1 800 | |
| Манжин | | кг | | | 1 900 | |
| Төмс | монгол | кг | | | 1 500 | |
| Лууван | монгол | кг | | | 1 800 | |
| Сонгино | хятад | кг | | | 2 750 | |
| | монгол | кг | | | 3 000 | |
| Сармис, булцуу | | ш | | | 823 | |
| Огурцы, хятад | | кг | | | 8 750 | |
| Помидор, хятад /үрлэн/ | | кг | | | 7 200 | |
| Ургамлын тос/ siesta/ | | ш | 12 000 | 10 000 | | 10 500 |
| Өндөг | | ш | 480 | 500 | | 500 |
| Талх | Есөн шанд том 900 гр | ш | 2 900 | 2 900 | | 2 900 |
| | Есөн шанд Дунд 700 гр | ш | 2 700 | 2 700 | | 2 700 |
| | Есөн шанд жижиг 500 гр | ш | 2 200 | 2 200 | | 2 200 |
| | Атар талх | ш | 2 200 | 2 200 | | 2 200 |

ЗУРАГ 14. "АЛТАН ТАРИА" ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн II сард




ЗУРАГ 15. НЭГ КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн II сард




ХҮСНЭГТ 12. ЦАХИЛГААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

| Хэрэглэгчдийн ангилал | Хэмжих нэгж | Тариф (НӨАТ-гүй) |
|---|---|---|
| ❋ Айл өрхөд борлуулах цахилгааны тариф | | |
| Энгийн тоолуууртай | | |
| • Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц | төг/квт.ц | 110.5 |
| • Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш | төг/квт.ц | 130.3 |
| 2 тарифт тоолууртай | | |
| • Өдрийн хэрэглээ /06.00-21.00/ | төг/квт.ц | 116.4 |
| • Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/ | төг/квт.ц | 89.2 |
| Сарын суурь тариф | төг/сар | 2 000.0 |
| ❋ Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф | | |
| Энгийн тоолуууртай | | |
| • Сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг | төг/квт.ц | 164.0 |
| • Сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас их хэрэглээг | төг/квт.ц | 187.0 |

3 тарифт тоолуууртай /сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг

| | | |
|---|---|---|
| • Өдрийн хэрэглээ /06.00-17.00/ | төг/квт.ц | 164.0 |
| • Оройн хэрэглээ /17.00-24.00/ | төг/квт.ц | 256.0 |
| • Шөнийн хэрэглээ /24.00-06.00/ | төг/квт.ц | 105.0 |

3 тарифт тоолуууртай /сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг

| | | |
|---|---|---|
| • Өдрийн хэрэглээ /06.00-17.00/ | төг/квт.ц | 187.0 |
| • Оройн хэрэглээ /17.00-24.00/ | төг/квт.ц | 291.0 |
| • Шөнийн хэрэглээ /24.00-06.00/ | төг/квт.ц | 121.0 |

* 2019 оны 3 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй айл өрхөд борлуулах тариф
*2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс мөрдөж буй үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад борлуулах тариф

## ХҮСНЭГТ 13. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

| Үзүүлэлт | | Хэмжих нэгж | Айл өрхөд (төгрөг) | Хэмжин нэгж | Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| Дулаан | | 1м$^2$ | 660 | 1м$^3$ | 1260 |
| Дулааны суурь тариф | | 40м$^2$ хүртэл | 3 000 | - | - |
| | | 41м$^2$ - 80м$^2$ | 5 000 | | |
| | | 81м$^2$-аас дээш | 10 000 | | |
| Халуун ус | Өвөл | 1 хүн (тоолуургүй) | 3 162 | 1 гкал | 84 272 |
| | | 1м$^3$ (тоолууртай) | 1 632 | | |
| | Зун | 1 хүн (тоолуургүй) | 4 428 | | |
| | | 1м$^3$ (тоолууртай) | 1 632 | | |
| Цэвэр ус* | | 1 хүн (тоолуургүй) | 1.5 | 1 л (тоолуургүй) | 1.50 |
| | | 1 л (тоолууртай) | 1.2 | 1 л (тоолууртай) | 1.20 |
| | | Ус түгээх байраар | 2.72 | 1 л (зөөврөөр) | 7.5 |
| Бохир ус* | | 1 хүн (тоолуургүй) | 1.5 | 1 л (тоолуургүй) | 1.8 |
| | | 1 л (тоолууртай) | 1.2 | 1 л (тоолууртай) | 1.4 |
| | | суурь хураамж | 15.0 | 1 л (зөөврөөр) | 1000 |

## ХҮСНЭГТ 14. МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

| | 2019 II | 2020 II | 2021 II | 2022 II | 2023 II |
|---|---|---|---|---|---|
| | төгрөг | | | | |
| Адууны шир | 8 000 | 8 500 | 5 000 | 7 500 | 8 000 |
| Үхрийн шир /2.3 метрээс доош/ | 7 500 | 4 500 | 5 000 | 4 500 | 7 500 |
| Үхрийн шир /2.3 метрээс дээш/ | 15 000 | 6 000 | 10 000 | 10 000 | 15 000 |
| Хонины арьс | 2 000 | 1 500 | 1 000 | 2 000 | 2 000 |
| Ямааны арьс | 30 000 | 28 000 | 15 000 | 35 000 | 30 000 |

ХҮСНЭГТ 15. ТҮЛШ ШАТАХУУНЫ ҮНЭ

| Шатахууны нэр төрөл | 2019 II | 2020 II | 2021 II | 2022 II | 2023 II |
|---|---|---|---|---|---|
| | төгрөг | | | | |
| АИ -76,80 | 1 738 | 1 810 | 1 450 | 2 295 | 2 420 |
| АИ -92 | 1 813 | 1 860 | 1 470 | 2 270 | 2 440 |
| Дизель түлш | 2 328 | 2 490 | 2 180 | 2 850 | 3 950 |

2023 оны 2 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин 125 (5.4%) төгрөгөөр, АИ-80 бензин 170 (7.5%) төгрөгөөр, дизель түлш 1100 (38.6%) төгрөгөөр тус тус өссөн байна.

## АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2023 оны эхний 2 сард 45.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 11.5 (33.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | Биет хэмжээ | | | Үнийн дүн, сая төгрөг | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022 I-II | 2023 I-II | 2023.I-II / 2022.I-II | 2022 I-II | 2023 I-II | 2023.I-II / 2022.I-II |
| Нүүрс олборлолт | м.тн | 954.0 | 988.8 | 103.6 | 31 959.0 | 42 824.9 | 134.0 |
| Дулаан дамжуулалт | м.гкал | 52.4 | 54.9 | 104.8 | 1 816.6 | 2 365.5 | 130.2 |
| Талх үйлдвэрлэлт | тн | 30.6 | 28.7 | 93.8 | 50.9 | 71.2 | 139.9 |
| Нарийн боов үйлдвэрлэлт | тн | 13.7 | 8.2 | 59.9 | 100.5 | 98.7 | 98.2 |
| Зайлуулсан хог хаягдал | м.м3 | 8.2 | 8.6 | 104.9 | 95.6 | 153.6 | 160.7 |
| **Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт** | | | | | **34 022.6** | **45 513.9** | **133.8** |

ЗУРАГ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар



Тайлант хугацаанд нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс 34.8 (3.6%) мянган тонноор буюу 10.8 (34.0%) тэрбум төгрөгөөр, дулаан үйлдвэрлэлт 2.5 (4.8%) мянган гкал-аар буюу 548.9 (30.2%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс талхны үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 1.9 (6.2%) тонноор буурч, үнийн дүнгээр 20.3 (39.9%) сая төгрөгөөр нэмэгдсэн бол, нарийн боовны үйлдвэрлэлт 5.5 (40.1%) тонноор буюу 1.8 (1.8%) сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 8.6 мянган метр куб хог зайлуулсан нь өмнөх оноос 0.4 (4.9%) мянган метр куб-ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 17. ТАЛХ, НАРИЙН БООВ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сараар, сая төгрөг




ЗУРАГ 18. НҮҮРС ОЛБОРЛОЛТ, мянган тонн, жил бүрийн 2 сард






## НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 757.5 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 266.5 (54.3%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 267.8 (35.4%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

ХҮСНЭГТ 17. ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ОРЛОГО, эхний II сард

| Үзүүлэлт | 2022 II | 2023 II | Өсөлт бууралт |
|---|---|---|---|
| | сая төгрөг | | |
| **Нийт орлого** | **491.0** | **757.5** | **266.5** |
| Орон сууц | 114.3 | 207.5 | 93.2 |
| Ус борлуулалт, бүгд | 227.7 | 359.9 | 132.2 |
| Хүн амд | 146.4 | 146.6 | 0.2 |
| Аж ахуйн нэгжид | 81.3 | 213.3 | 132 |
| Сувагжуулалт | 122.3 | 170.0 | 47.7 |
| Бусад | 26.7 | 20.1 | -6.6 |

ЗУРАГ 19. НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөг




ХҮСНЭГТ 18. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООДЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ, эхний II сард

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | ТБ% |
|---|---|---|---|
| | мянган төгрөг | | |
| **Нийт дүн** | 115198.4 | 94116.1 | 81.7 |
| Тавлаг өргөө | 20699.0 | 16461.0 | 79.5 |
| Маргад өргөө | 21057.2 | 14600.4 | 69.3 |
| Сод хөгжил | 23767.6 | 21740.9 | 91.5 |
| Шинэ элч | 21994.8 | 21417.8 | 97.4 |
| Уурхайчин | 13800.0 | 11400.0 | 82.6 |
| Содон суварга | 13879.8 | 8496.0 | 61.2 |

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2023 оны 3 дугаар сарын 15


WWW.1212.MN
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН
Статистик
Мэдээ, мэдээлэл
Номын сан
Мэдлэгээ шалгах тоглоом
Валютын ханш
©2017
1212
аппликейшнаас
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай
Data lab
тооллого судалгааны микро мэдээллийн сан
Social network
www.facebook.com/StatisticMongolia/
www.twitter.com/statistic_mn
Лавлах утас
1900-1212
Цахим шуудан
information@nso.mn